


Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 2019 оны статистик мэдээ


Монгол улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 2019 онд 7,003.3 сая кВт.ц болж өнгөрсөн оноос 5.7%-аар өссөн ба нийт үйлдвэрлэсэн цахилгааны 91%-ийг дулааны цахилгаан станцаар, 8.1%-ийн сэргээдэх эрчим хүчний эх үүсвэрээр, 1.2%-ийг усан цахилгаан станцаар, 0.04%-ийг дизель станцаар тус тус бүрдүүлсэн байна.

Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл 10,310.9 мян.Гкал байгаа нь өмнөх оноос 421.3 мян.Гкал буюу 4.3%-иар өсжээ. 2019 онд 1,715.8 сая кВт.ц цахилгааныг импортолсон нь өмнөх онтой харьцуулахад 32.2 сая кВт.ц цагаар буюу 1.9%-иар өссөн байна.




2019 оны гүйцэтгэлээр 229 үүрэг хүлээсэн хэрэглэгч Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний дотор улсын төсвийн 64, оффис, үйлчилгээний 33, хөнгөн хүнсний 54, уул уурхай, хүнд үйлдвэрийн 43 байгууллагууд нийлбэр дүнгээр 5205 сая кВт.ц цахилгаан эрчим хүч, 530 мянган Гкал дулааны эрчим хүчийг хэрэглэсэн байна. Эдгээр Үүрэг хүлээсэн хэрэглэгчид нь Монгол улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 40%-ийг хэрэглэж байна


2020 оны 1-р сарын байдлаар Үүрэг хүлээсэн 229 хэрэглэгчийг үйл ажиллагааны чиглэлээр ангилж харуулбал:



Эрчим хүчний хэрэглээний байдлаар харуулбал (сая кВт.ц):



Уул уурхай, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 30 байгууллагын хэрэглээг тооцохгүйгээр бусад үүрэг хүлээсэн хэрэглэгчийн цахилгаан болон дулааны эрчим хүчний хэрэглээг ангилж харуулбал:



Эрчим хүчний салбарын үүрэг хүлээсэн 34 хэрэглэгч 2019 онд эрчим хүч хэмнэх чиглэлээр 400 нэр төрлийн ажил, арга хэмжээ хэрэгжүүлэн 48.1 сая кВт.ц цахилгаан эрчим хүч, 44.6 мян.Гкал дулааны эрчим хүч буюу 4.8 тэрбум төгрөг, 2018 оноос хойших өссөн дүнгээр 81.3 сая кВт.ц цахилгаан эрчим хүч, 105,4 мян.Гкал дулааны эрчим хүч буюу мөнгөн дүнгээр илэрхийлбэл 12.1 тэрбум төгрөг хэмнэлт гарган ажилласан байна.

Мөн бусад Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хувьд 2018 онд 18,5 сая кВт.ц, 2019 онд 19,6 сая кВт.ц цахилгаан, дулааны эрчим хүчийг хэмнэж, өссөн дүнгээр 38,1 сая кВт.ц эрчим хүч буюу 5.3 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргажээ.

Үүрэг хүлээсэн хэрэглэгч нь Монгол улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 40%-ийг хэрэглэж байна.